



**СЭКЕРРЕСОРСУС
МОНГОЛИА**

Батлав: БОАЖЯ-ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА (А. ЭНХБАТ)

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-ийн ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
ЗАХИРАЛ (М. БАЯРМАНЛА)



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ ОРШИХ
ХОТГОРЫН УУРХАЙН MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062,
MV-021487, MV-021488 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТАЛБАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хянасан: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах
шинжээч (Ц. Жаргалнэмэх)

Боловсруулсан: “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн
Байгаль орчны мэргэжилтэн *Б. Дэлгэрэх* (Б. Дэлгэрэх)

2023 он

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч мэдээлэл.....	2-3
1.2. Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллаганы бүдүүвч схем.....	3
1.3. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт.....	3
1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	3-4
1.5. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал.....	4-7

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	
2.1.1. Агаар.....	7
2.1.2. Хөрс.....	8
2.1.3. Ус.....	8
2.1.4. Амьтан болон ургамал.....	9
2.2. Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа.....	9-12

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1. Тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	12
--	----

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13-14
4.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14-15
4.3. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15-16
4.4. Ургамлын аймаг, ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16-17

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....

11.1. Хөрсний хяналт шинжилгээ	
11.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ	
11.3. Усны чанарын хяналт шинжилгээ	

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч мэдээлэл

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК Хотгор нэртэй №7237Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн 490.15 га талбайг бүхэлд нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 4-р бүлгийн 24, 25 дугаар зүйлд заасан шаардлага, журмын дагуу 2007 оны 9-р сарын 21-нд MV-012728 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан. Мөн 2012 оны 6-р сард нэмж MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан.

Засаг захиргааны хувьд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км-ийн зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужын баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд далайн түвшинээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана.

Зураг №1. Талбайн байршил



1977-1978 онд Н.Авид Хотгорын чулуун нүүрсний ордыг шинээр илрүүлж 4 канав, 24 цооног буюу 1957т.м өрөмдлөгийн ажил гүйцэтгэж нүүрсний нөөцийг 4.09 сая.тн-оор тооцсон байдаг. 2007 оноос “Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд дамнан орших Хотгорын чулуун нүүрсний ордод геологи, геофизик, өрөмдлөгө хосолсон, нэмэлт нарийвчилсан хайгуулын ажлыг эхлүүлсэн.

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь 2019 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан, 2013 онд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг ашиглалтын талбайнуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулуулж, холбогдох байгууллагаар батлуулсан. Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 2011 оноос эхлэн археологийн авран хамгаалах хайгуул судалгаа, малтлага судалгааны ажлуудыг жил бүр шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Төслийн талбайд шинээр төлөвлөн баригдаж буй дэд бүтцийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012 онд тус тус хийлгэж холбогдох яамаар батлуулсан. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон биелэлтийг БОАЖЯ-аар жил бүр батлуулж, мөрдлөгө болгон ажиллаж байна.

1.2. Технологийн товч тайлбар, технологийн үйл ажиллаганы бүдүүвч схем

Ашиглалтын системийн элементүүд

Авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ирэх онд ажиллахаар төлөвлөж байна. Уулын ажлын цар хүрээ бага тул түрээсийн техникээр дээрх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1.3. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

Нүүрсэнд ажиллах механикжуулалтын бүтэц нь Экскаватор-автосамосвал гэсэн иж бүрдэлээр ажиллана. Уурхай нь 2020 оны IV улиралд нүүрс гаргах ба шаардлагатай тоног төхөөрөмжийг тухайн үед нь түрээсээр авч ажиллуулна. Түрээсийн төлбөрт дизель түлш, сэлбэг хэрэгсэл, элэгдлийн зардал орох бөгөөд түрээслэгч тал хариуцах болно.

Хүснэгт №1. 2023 онд Хотгорын уурхайд ажиллах тоног төхөөрөмж

Нэр	Марк	Хүчин чадал	Тоо ширхэг	Ээлж бүтээл м ³	Сар бүтээл м ³	Зарцуулах түлшний хэмжээ, тн	
						Ээлжинд	Сард
Экскаватор	Doosan 350	125 kW	1	1,800.0	18,000.0	160	1,22
Автосамосвал	Howo	6200CC/V8	3	420.0	12,600.0		1,78
Нийт			4				3,00

1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

Манай компани 2007-2022 онд Хотгорын уурхайд зөвхөн орон нутгийн иргэд, албан байгууллагуудад өвлийн дулааны хэрэгцээнд зориулж нүүрс олборлож ирсэн.

Харин 2023 онд хөрс хуулалтын ажил хийгдэхгүй ба орон нутаг болон Шинэжинст сумын албан байгууллагуудад өвлийн дулааны хэрэгцээнд III-р давхрагын блокоос 3000 тн нүүрсний нөөцөөс 2000 тн нүүрс олборлохоор төлөвлөсөн. болно. 2011 оны 11 сараас 2012 оны 8 сар хүртэл нийт 15 га талбайд 1,7 сая.м³ хөрс хуулсан учир энэ онд хөрс хуулалтын ажил хийгдэх шаардлагагүй

болно. Орон нутагт болон Шинэжинст сумын албан байгууллагуудад өвлийн дулааны хэрэгцээнд бага хэмжээний нүүрс олборлож гаргана.

Хүснэгт-2. Уулын ажлын төлөвлөлт

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	2023 он	Тайлбар
1	Нүүрс олборлолт	тонн	3000	Орон нутагт

Хайгуул, өрөмдлөг тэсэлгээний ажлын параметрууд

2023 онд хөрс хуулалтын ажил явагдахгүй орон нутаг болон Шинэжинст сумын дулааны хэрэгцээнд зориулан нүүрс олборлон гаргахаар төлөвлөсөн болно. Тиймээс орон нутаг болон Шинэжинст сумын дулааны хэрэгцээний нүүрсийг уурхайн авахад бэлэн нүүрсний мөргөцөгөөс хангана. Хөрс хуулалтын ажил хийгдэхгүй учир тэсэлгээ хийх шаардлагагүй болно.

1.5. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Баянхонгор аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт байрлаж Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудтай, урд талаараа БНХАУ-тай хил залгадаг ба нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 116 мянган ам километр болно. Нутгийн хойд хэсэгт Хангайн нурууны өмнө талын тэгш өндөрлөг, дунд хэсгээрээ Их нуруудын хотгорын төгсгөл тал хээр, өмнөд хэсгээрээ Алтайн цаад говийн цөлөрхөг хэсэгт хамаардаг.

Баянхонгор аймаг нь хөрс, цаг уурын олон бичил мужид хуваагддаг. Нар салхины эрчим хүчний нөөц сайтай ба Умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүссэн эрс тэс уур амьсгалтай.


Физик газар зүй

Хотгорын чулуун нүүрсний орд засаг захиргааны хувьд Монгол улсын баруун өмнөд хэсэг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км-ийн зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужын баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд оршино. Орд нь Говь-Алтайн нурууны дунд хэсэг (Баянцагааны нуруу, Шинэжинси уулын хооронд) оршдог тул ордын үндсэн хэсэг нь уул, толгодорхог, гадаргуутай районд багтах бөгөөд далайн түвшинээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана. Тус уурхайн талбайн хамгийн өндөр цэг нь Саманд уул ба түүний үнэмлэхүй өндөр нь далайн түвшинээс дээш 2347 метр юм. Талбайн гадаргуу нь гуу, жалгаар нэлээд хэрчигдэлтэй, тэдгээрийн адгуудад хошуурсан туугдсууд үүсч, өөрийн гэсэн онцлогтой чулуурхаг товгорхог гадаргууг үүсгэсэн байдаг. Орд газар нь Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг.

Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь-Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийн хамран говь хангайн бүсийг дамнан оршдог аймаг юм. Иймд нутаг нь уул тал хөндий хосолсон хэлбэр бүхий гадаргатай. дунд хэсэг Шинэжинст

сум нь өргөрөгийн 44°44'10", уртрагийн 100°23'40" солбицолд орших бөгөөд далайн түвшинээс дээш 1630 метр өндөрт байрладаг бөгөөд зүүн хойд талаараа Алтайн нурууны уулс, төв хэсгээр Улаанхан, Хартолгой, Хөндлөн зэрэг уулс, Өргөөтийн талууд оршино. Тус сумын хамгийн өндөр цэг Их Богд Уул 3957 метр, хамгийн нам цэг нь далайн түвшинээс дээш 1200 метр өндөр нутгийн захад оршино.

Зураг №3. Ашиглалтын талбайн агаар сансрын зураг



Уур амьсгал

Шинэжинст сум нь нутаг дэвсгэрийн мужлалаар говийн бүс, мелиорацийн мужлалаар умард говийн бүсэд, цаг уурын мужлалаар нэн хуурай дулаавтар мужид багтаж байна. Ордын район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсд багтана. Уур амьсгалын тодорхойлолтыг Шинэжинст цаг уурын өртөөний олон жилийн ажиглалтын мэдээг үндэслэн бичив. Цаг уурын шинэжинст өртөө нь 1972 оны сүүлчээр байгуулагдсан манай улсын цаг уурын сүлжээний нэг тулгуур цэг бөгөөд хойд өргөрөгийн 44°03', зүүн уртрагийн 99°16', далайн түвшнээс 2219,2 метр өндөрт оршино. Энэ бүс нутаг жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас ховор хэт хуурай. Жилдээ 120-180мм хур тунадас ордог бөгөөд хамгийн хүйтэн нь 1-р сард -30-35°C, харин зундаа 7-8-р сард хамгийн +25+30°C байдаг. Жилийн дундаж температур 0-(+1)°C-г хэлбэлзэх ба салхины чиглэл баруун, баруун урдаас зүүн, зүүн хойшоо байдаг, дундаж хурд нь 2.8-7.3 м/сек-ийн хооронд байна.

Өвөл: Эхний цас оролт 10-р сарын эхэнд орох ба хожуу цас оролт 10-р сарын 28-нд ордог. Эцсийн цас оролт 2-р дүгээр сарын 11-нд орох ба хожуу цас оролт 5-р сарын 15-нд ордог. Цасан бүрхүүлтэй өдрийн тоо 49 өдөр, цасан бүрхүүлийн нягт нь 0,6 г/см³ байдаг. Эцсийн хүйтрэл 5-р сарын 17-ны үеэр тохиолдох бөгөөд хүйтрэлгүй хугацааны дундаж үргэлжлэл нь 147 хоног байна.

Хавар: Тус сумын нутаг 4-р сарын 15-ний үеэр хавар эхэлж, 5-р сарын 3-ны үеэр шувтрах бөгөөд нийтдээ 18 хоног үргэлжилнэ.

Зун Харин зуны улирал 5-р сарын 3-ны үеэс хоногийн дундаж агаарын температур харин зундаа 7-8-р сард хамгийн халуун $+10^{\circ}\text{C}$ давж дулаарахаас эхлэн 10-р сарын 2 буюу $+10^{\circ}\text{C}$ -ийг давж сэрүүсэх хүртэл 152 хоног үргэлжилнэ.

Намар: Хоногийн дундаж агаарын температур $+10^{\circ}\text{C}$ -аас доошлох буюу -5°C болж сэрүүсэх хүртэлх хугацааг намрын улирал гэж монгол орны уур амьсгалын мужлалаар тогтоожээ. Тус сумын нутаг намар 10-р сарын 2-ний үеэр эхэлж, 11-р сарын 13-ний үеэр дуусаж дунджаар 41 хоног үргэлжилнэ.

Хөрс

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хөрсний төрөл, тархац үржил шим тариалангийн бүс, дэд бүс бүрт харилцан адилгүй байдлаар тархсан байдаг. Талбайн баруун талаар ухаа гүвээ толгодын маш нимгэн ялзмагт үеийн давхрагатай, карбонатлаг, цөлөрхөг хээрийн бор хөрс, дунд хэсгээрээ тал газрын ба уулсын хоорондох маш нимгэн ялзмагт үе давхрагатай, зузаан шороон үетэй. Талбайн баруун урд талдаа намхан уул, толгодтой бусад хэсэгтэй гүвээлэг болон тэгш, гадаргадаа жижиг үйрмэг чулуутай (10-15%). Өнгөн хөрс нь салхины элэгдэлд бага зэрэг орсон. Хөрсний ялзмагт үеийн зузаан 12 см, шороон үеийн зузаан нь 1.0-1.7 байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн нийт талбайд элс, элсэнцэр, хөнгөн шавранцар байна. Уур амьсгалын нөлөөгөөр говийн хөрсний ургамалт үе нь нимгэн байдгаас гадна хуурай, элсэрхэг байх ба шим тэжээл маш нимгэн байдаг.

Ургамал

Уурхайн талбайд ургамалын нөмрөгийн хувьд уулыг хээрийн Таана-заримдаг сөөгөнцөр-өдлөг хялганат, таана-үетэн-заримдаг сөөгөнцөрт гэсэн 2 төрлийн хэв шинжүүд бүлгэмдлүүд 15-25% бүрхэц үүсгэн 0.85-1.06ц/гаургацтай ургаж байна. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамаараад ургамалын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ. Голлон таана баглуур ургах ба хялгана, агь, тэсэг сийрэг бөгөөд тачир тархалттай байна.

Амьтны аймаг

Шинэжинст сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтын олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархацын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь ан амьтадаар нилээд баялаг, уул, асга, хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, ольби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиго, хуланжороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавьж болон жижиг далавчитнаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2012 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

2.1. Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн Хотгорын нүүрсний орд ашиглах үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн тодорхойлохдоо НҮБХХБ болон байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын “Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлал” зэргийг ашиглан гүйцэтгэгдсэн тооцоо, судалгаа үнэлгээний дүнг нэгтгэн тооцоолсон болно. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчинд үзүүлэх төслийн үйл ажиллагаа, түүний байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүртэй харилцан үйлчлэлцэх боломжийг магадлан жагсаахдаа “Баруун Хуасай” ХХК-ийн шинжээчид болон төслийн баг бүрэлдэхүүн хамтран гүйцэтгэсэн болно.

2.1.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Агаар орчны бохирдолт:

- Хөрс хуулалт
- Нүүрс олборлолт
- Овоолго

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр хээрийн анги орчим
- Шинэжинст сум, багийн оршин суугчид
- Амьтан
- Ургамал

2.1.2. Хөрсний чанарт үзүүлэх нөлөөлөл

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Мөн хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Шатахуун түгээх станц, авто засварын төв зэрэг нь хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй тул талбайг цементлэх шаардлагтай.

Хөрс бохирдолт

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон
- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн
- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

Нөлөөлөлд өртөх объект

- Шимт хөрс бүхий газар
- Малын бэлчээр
- Амьтан ургамал

2.1.3 Усны чанарт үзүүлэх нөлөөлөл

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорхи усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Гадаргын ба гүний ус

- Гадаргын ба гүний усанд одоогоор нөлөөлөл багатай

Нөлөөлөлд өртөх объект

- Хүн ба Мал
- Амьтан ургамал

2.1.4 Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа, хөрс хуулалт, автомашины хөдөлгөөн зэргээс ургамал талхлагдах доройтох зэрэгцээ тоос, ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож ургамлан бүрхэвч багасах нөлөөлөл үүснэ. Уурхайн үйл ажиллагааны дуу чимээ, автомашины хөдөлгөөн зэргээс шувууд, амьтад уурхайн талбай болон ойр орчмын талбайгаас дайжих нөлөөлөл үүснэ.

Болзошгүй нөлөөлөлийн эх үүсвэр

- Уулын бэлтгэл ажлууд

Зөвхөн албан хэрэгцээнд

- Уурхайн хөрс хуулалт ба карьер
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Олборлолт / нүүрс ачих тээвэрлэх /
- Хаягдал аж ахуйн /нүүрсний хаягдал, хаягдлын гадаад, дотоод овоолго /
- Талбайн гадаргын ус зайлуулах систем
- Шатах тослох материалын агуулах, шатахуун түгээх станц
- Зам, тээвэр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Хүн, машин механизм хөдөлгөөн

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхай орчмын ургамал амьтан

2.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа

Тус төслийн үйл ажиллагааны үйлдлийн хүрээ байгалийн хам бүрдлүүдэд үзүүлж болзошгүй нөлөөллийг НҮБ-ийн Ази номхон далайн Эдийн засаг, Нийгмийн комиссоор гаргасан байгаль орчны үнэлгээ хийх гарын авлагад заагдсан матрицын аргаар тооцоолох, төслийн бүтээгдэхүүн хэсгийг босоо тэнхлэгийн дагуу авч үзсэн. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл ялгаатай байх тул эдгээрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй нөлөөллийг тусган авч үнэллээ. Болзошгүй нөлөөллийн чухал байдлыг 1-5 баллаар үнэлэх ба дараах тэмдэглэлийг ашигласан болно. Үүнд:

1. Сөрөг нөлөөлөлгүй
2. Сөрөг нөлөөлөл бага
3. Сөрөг нөлөөлөл дунд зэрэг
4. Сөрөг нөлөөлөл их
5. Онц уршигтай сөрөг нөлөөлөлтэй

Хүснэгт-3. Төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагаа	Нөлөөлөлд өртөх объектууд	Шалгуур			Нийт түвшин
		Хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	
	Агаарын чанар	1	1	2	2
	Усны чанар	0	0	0	0
	Усны нөөц	0	0	0	0

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

Шимт хөрс хуулалт	Ургамлын бүтэц	3	1	3	9
	Амьтны аймаг	1	1	3	3
	Хөрсний хими физик чинж чанар	2	1	3	6
	Геологийн тогтоц	0	0	0	0
Шимт хөрс хадгалалт	Агаарын чанар	1	1	2	2
	Усны чанар	0	0	0	0
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	1	1	3	3
	Амьтны аймаг	1	1	1	1
	Хөрсний хими физик чинж чанар	1	1	3	3
	Геологийн тогтоц	0	0	0	0
Ухаж ачихад бэлтгэх	Агаарын чанар	1	1	3	3
	Усны чанар	2	2	3	12
	Усны нөөц	2	2	3	12
	Ургамлын бүтэц	1	1	3	3
	Амьтны аймаг	1	2	1	2
	Хөрсний хими физик чинж чанар	2	1	3	6
	Геологийн тогтоц	3	2	3	18
Өрөмдлөг тэсэлгээ	Агаарын чанар	1	2	3	6
	Усны чанар	2	2	3	12
	Усны нөөц	2	2	3	12
	Ургамлын бүтэц	1	1	3	3
	Амьтны аймаг	1	1	3	3
	Хөрсний хими физик чинж чанар	1	1	3	3
	Геологийн тогтоц	2	2	2	8
	Агаарын чанар	2	2	2	8

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

Хурдас чулуулгийг тээвэрлэх	Усны чанар	0	0	0	0
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	2	2	2	8
	Амьтны аймаг	2	2	2	8
	Хөрсний хими физик чинж чанар	2	2	2	8
	Геологийн тогтоц	0	0	0	0
Олборлолтын үйл ажиллагаа	Агаарын чанар	1	1	3	3
	Усны чанар	2	1	3	6
	Усны нөөц	2	1	3	6
	Ургамлын бүтэц	2	1	3	6
	Амьтны аймаг	1	1	1	1
	Хөрсний хими физик чинж чанар	1	1	3	3
	Геологийн тогтоц	3	3	3	6
Шатах тослох материалын агуулах	Агаарын чанар	2	1	2	4
	Усны чанар	2	1	2	4
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	2	1	3	6
	Амьтны аймаг	1	1	1	1
	Хөрсний хими физик чинж чанар	2	1	3	6
	Геологийн тогтоц	0	0	0	0
Дотоод зам	Агаарын чанар	2	2	3	12
	Усны чанар	1	1	1	1
	Усны нөөц	1	1	1	1
	Ургамлын бүтэц	3	2	3	18
	Амьтны аймаг	2	1	2	4
	Хөрсний хими физик чинж чанар	3	2	3	18

	Геологийн тогтоц	0	0	0	0
Уурхайн гадаад тээвэрлэлт	Агаарын чанар	1	3	3	9
	Усны чанар	1	1	1	1
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	2	3	3	18
	Амьтны аймаг	2	3	2	12
	Хөрсний хими физик чинж чанар	1	3	3	9
	Геологийн тогтоц	0	0	0	0

Болзошгүй нөлөөллийн үнэлгээний хүснэгтээс харахад төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны хам бүрдэл хэсэгт үзүүлж байгаа нөлөөллийн дундаж онооны утгатай үйл ажиллагаанд дотоод зам, малталт, олборлолтын үйл ажиллагаанууд орж байна

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллаж байна.

Тус уурхай нь санхүүгийн байдлаас хамаарч зөвхөн орон нутгийн хэрэгцээнд зориулж ажиллаж байгаа тул 2023 онд өргөн цар хүрээний ажил төлөвлөөгүй болно.

Мөн Монгол Улсын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгальд ээлтэй орчин үеийн технологи нэвтрүүлэх, байнгын хяналт, мониторинг хийх, олборлолтын бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх замаар байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчны зохистой бодлого барин ажиллаж байна.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: Хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, нүүрс болон хаягдал чулуулгын овоолгууд, ил уурхай, тэсэлгээ, түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 3. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Нүүрс олборлолтын үед Замаас үүсэх тоосжилтыг бууруулах- хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (Хурдын хязгаарын тэмдэг тэмдэглээг байршуулна.)	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замууд	Тэмдэг тэмдэглэгээ	6-с доошгүй	300,000₮	Жилийн турш	“Агаарын тухай” хууль болон “Агаарын бохирдолын тхай” хууль, MNS4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”
2.		Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах- Уурхайн олборлолтын үед туслан гүйцэтгэгч компанийн бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм,	Уурхайн олборлолтын үед ажил гүйцэтгэх гэрээт компаниудын тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм	Засвар үйлчилгээ	Тодорхойлох боломжгүй	Гэрээний дагуу- Гэрээт компани хариуцах	Хуваарийн дагуу	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

	Тээврийн хэрэгсэлийн яндангаас утаа болон хорт хий ялгарч агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл	техникийг холбогдох үзлэгт хамруулсан, засвар үйлчилгээ хийсэн байх шаардлагыг ажил гүйцэтгэх гэрээнд зааж, хяналт тавьж ажиллана.						“Агаарын тухай” болон “Агаарын бохирдолын төлбөрийн тухай” хууль,	
3.	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Өөрийн компанийн уурхай дээр ажиллах техник хэрэгсэлүүдийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.	Уурхайн дэд бүтцийн шугамын дагуу ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгсэл	Засвар үйлчилгээ	4	Дотоод зардлаар	Жилийн турш		
4.	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Дулааны станц, бусад сумдад нийлүүлэх нүүрс тээвэрлэгч тээврийн машиныг бүтээлгэтэй байлгахад хяналт тавьна.	Нүүрс тээвэрлэлтийн зам дагуу	Тээвэрлэлтийн тоо	Тодорхойлох боломжгүй	Гэрээт компанийн зардлаар	Жилийн турш	“Агаарын тухай” хууль MNS4585:2007 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”	
Нийт							300,000		

4.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Ирэх 2023 онд байгаль орчны холбогдох хууль тогтоомж, компанийн байгаль орчны бодлогийн хэрэгжилтийг ханган, хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 4. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах хадгалах	Аливаа газар хөндөлтийн үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж хадгална. (Газар хөндөлтийн үйл ажиллагаа явуулахгүй байх магадлалтай)	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Хөрс хуулах зөвлөмж олгосон талбайн тоо хэмжээ	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Дотоод зардлаар	Жилийн турш	MNS5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадаглалт
2.		Шимт хөрсийг хадгалж хамгаална.	Уурхайн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Шинээр шимт хөрсний овоолго үүсгэх	Шимт хөрсний хуулалт хийгдэх бүрт			
Нийт						-		

4.3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 5. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Газрын доор усыг ашигласнаар	Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглалтын төлбөрийг	Уурхайн хүрээнд	Ашигласан усны хэмжээнээс хамаарч тооцно.				Усны тухай хууль болон

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

	усны нөөц хомсдох, усны нөөцөд	гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлөх						холбогдох дүрэм журам
2	хохирол учирч болзошгүй	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, дүгнэлтэнд зааснаас бусад зориулалтаар ашиглах Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	Төслийн хүрээнд	Усны төлбөрт төлсөн мөнгөн дүн	Баталгаажсан усны тоолуурын заалт	300,000₮	Жилийн турш	
3.		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Уурхайн ажилтнуудад		Сургалтанд хамрагдсан ажилтнуудын тоо	500,000₮	Жилийн турш	
4.	Ундны усны чанар алдагдах	Ундны усыг тогтмол хугацаанд шинжлэх	Уухай, сумын хүрээнд	Усны хэмжсэн үзүүлэлт	2	200,000₮	Жилд 2 удаа	Усны тухай хууль, усан орчны чанарын үзүүлэлт
Нийт						1,000,000		

4.4. Ургамлын аймаг, ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Ирэх 2023 онд ургамлын аймаг, ургамалан нөмрөг, ховор ургамлын хамгааллын хүрээнд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах ажлуудыг төлөвлөөд байна.

Хүснэгт 6. Ургамлын аймаг, ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Уурхайн үйл ажиллагаанд ухагдах, дарагдах, талбайн бүх ургамлан бүрхэвч устгах	Хүнд даацын машин техник болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах, олон салаа зам	Уурхайн хэмжээнд болон сумаас уурхай хүртэлх зам	Тэмдэглэгээ байршуулах	4	Дотоод зардлаар	3-дугаар улиралд	MNS5918:2008 эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий

		гаргахгүй байна. замыг тэмдэгжүүлнэ.						шаардлага, Авто замын тухай хууль
Нийт							-	

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зээгтийн уурхайн үйл ажиллагаа орон нутгийн хэрэгцээнд зориулж улирлын чанартай, бага хүчин чадлаар ажиллаж байна. Олборлолт явагдаж буй талбай нь 25 метрийн гүнтэй байгаа ба цаашид тус талбайд үргэлжлүүлэн олборлолт болон хөрс хуулалтын ажил хийгдэх тул нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй болно.

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дагуу “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 онд Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллах хиймэл нүүр (Тэргүүн тэргэл)-н ойр орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 1,5 га хүртэлх талбайд 2,500,000 ширхэг хайлаас сонгон тариалсан. Энэ ажлын үргэлжлэл болгон 2023 онд дараах ажлуудыг төлөвлөөд байна.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод бут тарих, арчлах хамгаалах	2022 онд хашаалсан 1.2 га талбайн ойн зурвасыг нөхөн, нөхөн тариалалтыг хийх ажлын хүрээнд 1000 ширхэг мод тарих ажлыг орон нутгийн мод үржүүлгийн газартай хамтран зохион байгуулна.	Шинэжинст сумын ногоон байгууламжийн хашаанд	1000	5000	5,000,000	2-р улиралд	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай
2.		Өнгөрсөн онд тариалсан мод болон шинээр тариалах мод бутны арчилгаа усалгааг тогтмол хийж амьдралтыг 85%-иас доошгүй байлгана.	Тариалсан ногоон байгууламжинд	2400	150,000	Дотоод зардлаар	Жилийн турш	
Нийт						5,000,000₮		

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хотгорын уурхайн MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбай болон нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор айл өрх байхгүй тул энэ талаарх ажил хийгдэхээргүй байна.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Соёлын өв гэдэгт орон нутагт ёс уламжлалын дагуу өв уламжлагдсан буюу түүхэн ач холбогдолтой, орон нутгийнхны нийтээр хүлээн зөвшөөрсөн биет болон биет бус өвийг хамруулан авч үздэг. Бид үйл ажиллагаагаа явуулж буй орон нутгийнхаа түүх, соёлын өвийг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилгоор 2023 онд дараах ажлыг төлөвлөөд байна.

Хүснэгт 8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх, түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Биет болон биет бус өв	Төслийн ажилтнуудад Орон нутгийн харилцааны болон Соёлын өвийн зааварчилгаа өгөх, дурсгалт зүйлс олдох үед мэдээллэх хадгалах арга зүйн зааварчилгаа өгөх	Төслийн ажилтнууд, гэрээт байгууллагын ажилтнууд	Нийт ажилтнууд	-	500,000	Жилийн турш	МУ-н Соёлын өвийн тухай хууль тогтоомж
2.		Уурхайн нөлөөллийн бүсэд түүх соёлын өв олдох үед холбогдох дүрэм журмын дагуу хамгаалалтанд авч ажиллана.			-	-		
Нийт						500,000₮		

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Гал түймэр	Уурхайн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламж	Шинээр суурилуулах, хугацаа дууссанг цэнэглэх	300,000	300,000	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшигаас хамгаалах тухай хууль
2.		Галын болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнууд	1	250,000	250,000	Жилийн турш	
3	ХАБЭА	ХАБЭА-н сургалтын жилд 2 удаа зохион байгуулсан байх	Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнууд	2	250,000	500,000	Жилийн турш	ХАБЭА-н тухай хууль, Компанийн холбогдох дүрэм журам
4		Гэрээт компанийн ажилтнуудад өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгөх	Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнууд	Тухай бүрд	-	-	Олборлолтын үйл ажиллагааны үеэр	
Нийт						1,050,000₮		

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүд дээр байрлуулж ашигладаг.

2023 онд хог хаягдалын менежментээ илүү сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг төлөвлөөд байна.

Хүснэгт 10. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

№	Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн болон үйлдвэрлэлийн	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдалыг ангилан ялгах 1 тонны хэмжээтэй хогийн сав байршуулна.	Уурхайн хэмжээнд	тн	1	2,500,000	Жилийн турш	Хог хаягдалын тухай хууль
		Сумтай хог хаягдалын гэрээ байгуулан хамтран ажиллах сумын хогийн цэгт хаясан хог хаягдалын хаяна.	Уурхайн хэмжээнд	тн		140,000	Жилийн турш	
	Аюултай хог хаягдал	Хог хаягдалыг дахин боловсруулах, ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллана.	Уурхайн хэмжээнд	Нэгж уулзалт		Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу	Жилийн турш	
Нийт						2,640,000₮		

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

11.1. Хөрсний хяналт шинжилгээ

Уурхайн үйл ажиллагааны үр дүнд хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжинд гарч болох өөрчлөлт, мөн түүнчлэн хөрсний чанар нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор хяналт шинжилгээтэй холбоотой доорх ажлыг 2023 онд хийхээр төлөвлөж байна

Хүснэгт 11. Хөрсний хяналт шинжилгээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хөрсний чанар-Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	1. Уурхайн технологийн замын хажуу талаас 2. Кемпийн хашаан дотроос 3. Нүүрс цагаалсан талбайгаас	Жилд 2 удаа 6 сар, болон 11 сард	1	180,000	360,000	Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр хийлгэнэ	MNS5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5859:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөхөгдөх хэмжээ
Нийт						360,000₮		

11.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Зээгтийн уурхайн талбай нь Монгол орны уур амьсгалын мужлалаар гандуу дулаан зунтай бүсийн, хүйтэн өвөлтэй мужид байрладаг. Энэ утгаараа бусад бүс нутгуудтай харьцуулахад хур тунадас бага, хуурайшилт ихтэйгээс гадна, салхины хурд өндөр байдаг буюу тоосжилт үүсэх байгалийн суурь нөхцөлтэй зэргээс агаарын чанарт үзүүлэх нөлөөг хянахын тулд дараах ажлыг төлөвлөөд байна.

Хүснэгт 12. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Агаарын чанар	Уурхайн талбайн 3 цэгээс	Жилд 2 удаа 6 сар, болон 11 сард		360,000	720,000	Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр хийлгэнэ	MNS4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
Нийт						720,000		

11.3. Усны чанарын хяналт шинжилгээ

Хүснэгт 13. Усны чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Усны чанарын шинжилгээ	Уурхайн эзэмшлийн 2 худаг, мониторингийн 2 худаг,	Жилд 2 удаа 6 сар, болон 11 сард		70,000	140,000	Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр хийлгэнэ	MNS4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
Нийт						140,000		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн Байгаль орчны баг нь Байгаль орчин , Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэст харьяалагддаг бөгөөд 2 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид энэ жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө оруулсан төлөвлөгөөт ажлуудаа сумын засаг захиргаа, байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран үр дүн чанартай зохион байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Зураг №4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчны хэлтсийн бүтэц орон тоо



2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авахаар төлөвлөөд байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

Хүснэгт 13. “Байгаль орчны тэмдэглэлт ногоон” өдөрлөгүүдийг зохион байгуулж иргэд, олон нийтийн байгаль экологийн талаарх боловсрол, мэдлэг, ухамсарыг нэмэгдүүлэх

№	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд	Хугацаа	Зардал	Арга хэмжээний нар хүрээ	Хариуцсан албан тушаалтан	Арга хэмжээ
1.	Дэлхийн усны өдөр	3-р сарын 22	300,000	Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургууль	Б.Дэлгэрэх Сургуулийн захиргаа, Сумын захиргаа	Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 5-10 р ангийн сурагчдын дунд “Усаа хайрлая” гар зургийн уралдаан зохион байгуулах
2.	Мод тарих үндэсний өдөр	5, 10 сард	500,000	Шинэжинст сумын хэмжээнд	Б.Дэлгэрэх Сумын ИТХ	Шинэжинст сумын Иргэдийн төлөөлөл, 9-12 р ангийн сурагчидтай хамтран мод тарих үндэсний өдрийг зохион байгуулна.
3.	Байгаль хамгаалах сарын аян зарлах	5 дугаар сард	500,000	Шинэжинст сумын хэмжээнд	Б.Дэлгэрэх Сумын захиргаа	Сумын байгаль хамгааллын ажилтнуудтай хамтран аяны хугацаанд зохион байгуулна.
Нийт			1,300,000			

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1.	2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг орон	Танилцуулга хийх	2022 оны Байгаль орчны төлөвлөгөөний биелэлт, үр дүн	2023 оны 1-р улирал	Тодорхойгүй Томилолтын зардал 1,200,000₮	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

	нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах						
2.	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулж санал авах	Танилцуулгыг хүргүүлэх	2023 онд Байгаль орчны чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг танилцуулах	2023 оны 1-дүгээр улирал	Тодорхойгүй	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум
3.	<u>Тэмдэглэлт өдрүүд:</u> Дэлхийн усны өдөр, Мод тарих үндэсний өдөр, Байгаль хамгаалах сарын аян гэх мэт тэмдэглэлт өдрүүд Чандмань сумын дунд сургуулийн сурагчдад чиглэсэн танин мэдэхүйн арга хэмжээнүүд зохион байгуулна	Үйл ажиллагааны тайлан, хамрагдсан байгууллага, оролцсон хүүхдүүдийн тоо	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох, олон нийтийн тэмдэглэлт өдрүүдийг хамтран зохион байгуулах	Тогтсон өдрүүдэд	1,300,000	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум
4.	Булгийн эх түүний ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны тайлан	Уурхайн ажилтнуудыг оролцуулан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулна	Жилд 2 удаа	Дотоод зардлаар	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум
5.	Байгаль орчин болон байгаль орчны тэмдэглэлт өдрүүдтэй холбоотой мэдээ тайланг сумыны нэгдсэн группуудэд мэдээлэн танилцуулах, тайлагнах	Үйл ажиллагааны тайлан	Үйл ажиллагааны цар хүрээ, зар мэдээлэл, талархалын постууд	Товлосон өдрүүдэд	Дотоод зардлаар	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум
5.	2023 оны БОМТ-н биелэлтийг сумын ИТХ-засаг захиргаанд тайлагнах	Танилцуулга хийх	2023 онд Байгаль орчны төлөвлөгөөнд тусгагдсан	2023 оны 4-р улиралд	Тодорхойгүй	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Хотгорын уурхай 2023 он

			ажлуудын биелэлт				
6.	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт	Танилцуулга хийх	Төлөвлөгөөний агуулгын дагуу	2023 оны 4-р улиралд	Тодорхойгүй	Б.Дэлгэрэх	Шинэжинст сум Зээгтийн уурхай
Нийт				2,500,000			

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн төсвийн задаргаа

№	Арга хэмжээ	Төсөв
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	1,300,000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний төсөв	
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	5,000,000
4.	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	
5.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв	500,000
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	1,050,000
7.	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний төсөв	2,640,000
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв	1,220,000
9.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1,300,000
10.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний төсөв	2,500,000
Нийт		15,510,000₮